



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/128

Мандалговь

Г Хүндэтгэл үзүүлэх тухай Г

Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын 2014 оны А/316 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалыг олгох, хөрөнгө зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 6 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлгэрхангай сумын уугуул, Үндэсний Урлагийн их театрын гоцлол дуучин, уртын дуучин С.Цогтсайхан Төрийн дээд шагнал “Монгол Улсын Гавьяат жүжигчин” цол хүртэж, аймаг орон нутагтаа “Амар мэндийн аялгуу” аялан тоглолтоо хийсэнтэй холбогдуулан хүрэлцэн ирсэн уран бүтээлчидэд аймгийн Засаг даргын зоог барьж, хүндэтгэл үзүүлсүгэй.

Хоёр. Хүндэтгэл үзүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Хүндэтгэлийн зоог барихад нийт 612880 /Зургаан зуун арван хоёр мянга найман зуун наян/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

020000363